



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ГАДААД СЕКТОРЫН СТАТИСТИК

Танилцуулга
2020 оны 2 дугаар улирал

Улаанбаатар
2020




1. Төлбөрийн тэнцэл

Урсгал ба хөрөнгийн данс 2020 оны 2 дугаар улиралд 201 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 109 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 329 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -237 сая ам.доллар байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 111 сая ам.доллараар, санхүүгийн дансны ашиг 432 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 3,556 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 9.1 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)




Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16%-аар буурч 3,047 сая ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 442 сая ам.долларын ашигтай гарсан.

Тодруулбал, экспортын хувьд, чулуун нүүрсний экспорт 461 сая ам.доллараар (51%), зэсийн баяжмал 168 сая ам.доллараар (30%), боловсруулаагүй нефть 75 сая ам.доллараар (82%), СИФ нөхцөлөөр тооцсон нефтийн бүтээгдэхүүний импорт 101 сая ам.доллараар (40%), хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 170 сая ам.доллараар (23%) тус тус буурсан. Улмаар барааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 65 сая ам.доллараар буурчээ.


Дүрслэл 2. Барааны худалдаа (сая ам.доллар)



Үйлчилгээний худалдаа


2020 оны 2 дугаар улирлын гүйцэтгэлээр үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 13%-аар буюу 59 сая ам.доллараар буурч, 398 сая ам.долларт хүрсэн. Үүнд тээврийн үйлчилгээний алдагдал 110 сая ам.доллараар, бизнесийн бусад үйлчилгээний алдагдал 29 сая ам.доллараар буурсан, аяллын үйлчилгээний алдагдал 71 сая ам.доллараар өссөн нь тус тус голлон нөлөөлсөн байна (Дүрслэл 3).

Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа (сая ам.доллар)




Үйлчилгээний экспорт өмнөх оны мөн үеэс 54%-аар буюу 165 сая ам.доллараар буурч 141 сая ам.долларт хүрчээ. Үүний 56% буюу 79 сая ам.долларыг тээвэр, 9% буюу 13 сая ам.долларыг харилцаа холбоо, компьютер, 25% буюу 35 сая ам.долларыг бизнесийн бусад үйлчилгээний экспортын орлого бүрдүүлж байна (Дүрслэл 4).

Дүрслэл 4. Үйлчилгээний экспорт (сая ам.доллар)



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлчилгээний импорт 29%-аар буюу 224 сая ам.доллараар буурч, 539 сая ам.долларт хүрсэн. Дээрх зардлын 28%-ийг буюу 152 сая ам.долларыг бизнесийн бусад, 26%-ийг буюу 140 сая ам.долларыг аялал жуулчлал, 25%-ийг буюу 137 сая ам.долларыг тээвэр, 9%-ийг буюу 51 сая ам.долларыг барилга, барилгын үйлчилгээ авахад тус тус зарцуулжээ.

Дүрслэл 5. Үйлчилгээний импорт (сая ам.доллар)




Аялал жуулчлалын үйлчилгээ

Сүүлийн 2 жилийн дунджаар аялал жуулчлалын үйлчилгээний дансны орлого нь манай улсын нийт үйлчилгээний экспортын 38%-ийг, зарлага нь нийт үйлчилгээний импортын 29%-ийг бүрдүүлсэн байна.


Тэгвэл аялал жуулчлалын үйлчилгээний салбарын орлогын 23%-ийг БНСУ, 19%-ийг БНХАУ, 13%-ийг ОХУ, 4%-ийг Япон, 32%-ийг бусад улсын аялагчдад үзүүлсэн үйлчилгээнээс хүлээн авсан байна.

Дүрслэл 6. Аялалын үйлчилгээний экспорт, 2018.III-2020.II (сая ам.доллар)



Харин аялал жуулчлалын салбарын импортыг улсаар нь ангилбал: Монгол улсын иргэд нийт зардлын 19%-ийг Япон, 17%-ийг БНСУ-д, 11%-ийг АНУ, 6%-ийг ОХУ, 6%-ийг БНХАУ-д аялахдаа зарцуулсан байна.


Дүрслэл 7. Аялалын үйлчилгээний импорт, 2018.III-2020.II (сая ам.доллар)



Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 331 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 22%-аар буюу 94 сая ам.доллараар буурсан үзүүлэлтэй байна. Үүнд хөрөнгө оруулалтын орлогын дансны алдагдал голчлон нөлөөлсөн. Тайлант улиралд манай улс гадаад бонд, үнэт цаасны хүүгийн төлбөрт 90 сая ам.доллар, ногдол ашигт 27 сая ам.доллар, шууд хөрөнгө оруулагчийн зээлийн хүүгийн төлбөрт 135 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 163 сая ам.доллар, харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт 0.04 сая ам.долларыг тус тус төлсөн байна.

Дүрслэл 8. Анхдагч орлого (сая ам.доллар)



Хоёрдогч орлого

Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн шугамаар 2020 оны 2 дугаар улиралд Монгол улс нийт 65 сая ам.долларыг буюу өнгөрсөн оны мөн үеэс 19 сая ам.доллараар их орлого хүлээн авчээ. Дэлгэрүүлбэл:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулга өмнөх оноос 10%-аар, харин гадаад руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 32%-аар тус тус буурсан байна.
- Хандив тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 15 сая ам.доллараар өссөн байна.

Хүснэгт 1. Хувийн гуйвуулга 2020.II (мян ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Дүн	Хувь	Өсөлт	Дүн	Хувь	Өсөлт
Солонгос	21,878	38% ▼	-27%	3,092	15% ▼	-61%
Америк	3,852	7% ▼	-44%	3,244	15% ▼	-38%
Хятад	409	1% ▲	47%	494	2% ▼	-49%
Гонг Конг	291	1% ▼	-68%	228	1% ▼	-59%
Англи	2,611	4% ▲	244%	1,244	6% ▼	-35%
ОХУ	12,192	21% ▲	15%	1,988	9% ▼	-81%
Сингапур	5,351	9% ▲	239%	719	3% ▼	-53%
Швейцарь	1,111	2% ▼	-41%	76	0% ▼	-73%
Герман	1,559	3% ▼	-29%	531	3% ▼	-21%
Япон	499	1% ▼	-62%	648	3% ▼	-54%
Бусад	8,362	14% ▼	-26%	8,747	42% ▼	-17%
НИЙТ	58,116	100%		21,009	100%	

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2020 оны 2 дугаар улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 747 сая ам.доллар, харин хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 195 сая ам.доллар буюу цэвэр дүнгээр 552 сая ам.долларын орох урсгалтай байв.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 51 сая ам.доллараар буурсан дүнтэй байна.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг голлох улсаар нь харвал:

- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 84 сая ам.доллараар өсч, 483 сая ам.доллар,
- Их Британи улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 73 сая ам.доллараар өсч, 92 сая ам.доллар,
- Хонг-Конг улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 104 сая ам.доллараар буурч, 6 сая ам.доллар,
- БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 30 сая ам.доллараар буурч, 43 сая ам.долларын орох урсгалтай байсан байна.

Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	2020		2020.II/19.II	
		Дүн	Хувь	Өөрчлөлт	
1	Австрали	1	0%	-3	▼
2	АНУ	28	4%	-14	▼
3	Их Британи	92	12%	73	▲
4	БНХАУ	43	6%	-30	▼
5	Герман	1	0%	-9	▼
6	Нидерланд	0	0%	0	▼
7	Хонг-Конг	6	1%	-104	▼
8	Канад	483	65%	84	▲
9	Люксембург	8	1%	2	▲
10	ОХУ	5	1%	1	▲
11	Сингапур	43	6%	10	▲
12	Солонгос (өмнөд)	1	0%	-3	▼
13	Турк	0	0%	-1	▼
14	Франц	3	0%	-2	▼
15	Япон	25	3%	-10	▼
16	Бусад	8	1%	-43	▼
	Нийт	747	100%	-51	▼

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл:

- Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээний салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт 76 сая ам.доллараар,
- Уул уурхайн салбар 22 сая ам.доллараар тус тус өссөн бол,
- Бөөний болон жижиглэн худалдааны салбар 116 сая ам.доллараар,
- Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар 46 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	II улирал		2020.II/19.II	Өөрчлөлт
		2019	2020		
1	Барилга	15	31	16	▲
2	Боловсрол	1	0	-1	▼
3	Боловсруулах үйлдвэрлэл	10	9	0	▼
4	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	146	29	-116	▼
5	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	6	0	-6	▼
6	Мэдээлэл, холбоо	0	1	1	▲
7	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3	11	9	▲
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	78	32	-46	▼
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0	9	9	▲
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл	18	94	76	▲
11	Уул уурхай, олборлолт	492	514	22	▲
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	23	14	-9	▼
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	5	3	-2	▼
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан	1	0	-1	▼
15	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0	0	0	▼
16	Бусад	0	0	0	▲
Нийт		798	747	-51	▲


Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2020 оны 2 дугаар улиралд 576 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад ашиг 595 сая ам.доллараар буурсан.

Тайлант улирлын голлох ажил гүйлгээг дурдвал:

- Худалдаа хөгжлийн банкны бондын үндсэн болон хүүгийн төлбөрт 522 сая ам.доллар,
- Энержи Ресурс бондын хүүгийн төлбөрт 20 сая ам.доллар,
- Хөгжлийн банкны бондын хүүгийн төлбөрт 18 сая ам.доллар,
- Мазаалай бондын хүүгийн төлбөрт 27 сая ам.доллар,
- Гэрэгэ бондын хүүгийн төлбөрт 23 сая ам.доллар,
- Чингис бондын хүүгийн төлбөрт 26 сая ам.долларыг эдийн засгийн харьяат буст тус тус төлсөн байна.


Дүрслэл 9. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд өмнөх санхүүгийн дансуудад үл хамаарах арилжааны болон хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, худалдааны зээллэг, бэлэн мөнгө ба харилцах хадгаламж зэрэг бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүртгэдэг. 2020 оны 2 дугаар улиралд бусад хөрөнгө оруулалтын данс цэвэр дүнгээр 138 сая ам.долларын орох урсгалтай буюу өнгөрсөн оны мөн үеэс 186 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлттэй байна. Энэ өөрчлөлтөд Засгийн газар болон Монголбанкны зээлийн ашиглалт өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Дүрслэл 10. Бусад хөрөнгө оруулалт



2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2020 оны 2 дугаар улиралд цэвэр дүнгээр 36,488 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 6,846 сая ам.доллар байна. Үүний 52%-ийг гадаад валютын албан нөөц, 33%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 10%-ийг шууд хөрөнгө оруулалт, 5%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 43,334 сая ам.долларт хүрчээ. Үүний 54%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 36%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 10%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 6%-аар буюу 1,988 сая ам.доллараар өссөн байна.

Үүнийг ерөнхий бүтцээр авч үзвэл: гадаад актив 0.4%-аар буюу 28 сая ам.доллараар буурч, гадаад пассив 5%-аар буюу 1,960 сая ам.доллараар өссөн.


Харин дансаар нь авч үзвэл: гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 2,116 сая ам.доллар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 461 сая ам.доллараар өссөн. Харин багцын хөрөнгө оруулалтын богино позиц 1,133 сая ам.доллараар, албан нөөц 545 сая ам.доллараар тус тус буурсан байна.

Тайлант улирлын позицгийн нийт өөрчлөлтийг авч үзвэл: төлбөрийн тэнцлийн урсгалаар -438 сая ам.доллар, бусад өөрчлөлтөөр -292 сая ам.доллар, үнийн өөрчлөлтөөр -159 сая ам.доллар, ханшийн өөрчлөлтөөр 84 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	6/30/2019	6/30/2020	Өөрчлөлт	
			дүн	хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-34,501	-36,488	1,988	6%
I. Гадаад актив	6,874	6,846	-28	0%
1. Шууд хөрөнгө оруулалт	565	688	123	22%
2. Багцын хөрөнгө оруулалт	288	320	32	11%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	6	7	2	35%
4. Бусад хөрөнгө оруулалт	1,921	2,282	361	19%
5. Нөөц актив	4,094	3,548	-545	-13%
II. Гадаад пассив	41,375	43,334	1,960	5%
1. Шууд хөрөнгө оруулалт	21,230	23,469	2,239	11%
2. Багцын хөрөнгө оруулалт	5,431	4,329	-1,101	-20%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	1	1	1125%
4. Бусад хөрөнгө оруулалт	14,714	15,535	822	6%

Дүрслэл 11. Гадаад актив, пассив (сая ам.доллар)



Шууд хөрөнгө оруулалт


Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 53%-ийг буюу 12,438 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 47% буюу 11,030 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл

(компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Манай улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- Канад улсаас 8,559 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 36%,
- БНХАУ-аас 5,087 сая ам.доллар буюу 22%,
- Сингапур улсаас 1,478 сая ам.доллар буюу 6%,
- Люксембург улсаас 1,476 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 6%-ийг тус тус бүрдүүлж байна.

Дүрслэл 12. Шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл, 2020.II



Багцын хөрөнгө оруулалт


Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2020 оны 2 дугаар улиралд 320 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 11%-аар өссөн бол гадаад пассивын үлдэгдэл 4,329 сая ам.долларт хүрч 20%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Актив: манай эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл: Хонг-Конг 31%, АНУ 16%, Сингапур 11%, Австрали 7%, Их Британ 6%-ийг тус тус эзэлж байна.

Пассив: Монголын эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал: АНУ 26%, Их

Британ 12%, Люксембург 6%, Сингапур 4%, Герман 3%, үлдсэн 27% нь хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа тул хөрөнгө оруулагчийн харьяалах улсыг тодорхойлох боломжгүй байна.

Дүрслэл 13. Багцын ХО-ын үлдэгдэл, 2020.II (сая ам.доллар)



3. Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2020 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 30,814 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,121 сая ам.доллараар өссөн байна.

Улсын салбар: Засгийн газрын гадаад өр 645 сая ам.доллараар өсч 7,891 сая ам.долларт, Монголбанкны гадаад өр 50 сая ам.доллараар өсч 2,084 сая ам.долларт хүрчээ.

Бусад салбар: Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд энэ дүн өнгөрсөн оны мөн үеэс 426 сая ам.доллараар өсч 20,839 сая ам.долларт хүрээд байна.

Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар).

Үзүүлэлт	6/30/2019	6/30/2020	өөрчлөлт		* %
			дүн	хувь	
Нийт гадаад өр	29,693	30,814	1,121	4%	100%
I. Засгийн газар	7,246	7,891	645	9%	26%
Бонд, өрийн бичиг	2,941	2,753	-188	-6%	
Зээл	4,306	5,139	833	19%	
II. Төв банк	2,034	2,084	50	2%	7%
III. Банк	2,245	1,703	-542	-24%	6%
Богино хугацаат	722	600	-122	-17%	2%
Урт хугацаат	1,523	1,103	-420	-28%	4%
IV. Бусад сектор	8,509	8,106	-403	-5%	26%
Богино хугацаат	662	498	-164	-25%	2%
Урт хугацаат	7,847	7,608	-239	-3%	25%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	9,659	11,030	1,371	14%	36%

*: Нийт өсөлтөөд оруулсан хувь


Банкны салбар

Банкны салбарын гадаад өрийн үлдэгдэл 2020 оны 2 дугаар улирлын эцэст 1,703 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 542 сая ам.доллараар буурчээ.

Гадаад өрийн 60%-ийг урт хугацаат зээл, 19%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг, 16%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 5%-ийг бонд өрийн бичиг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 1,017 сая ам.доллар, 270 сая ам.долларт хүрэв.

Дүрслэл 14. Банкны салбарын гадаад өр (сая ам.доллар)



Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр төлбөр 2020 оны 2 дугаар улирлын эцэст 19,136 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 968 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 58% буюу 11,030 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани

хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.

Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа, төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 288 сая ам.доллар болсон байна.

Мэдээллийн эх сурвалж:


Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс

Монголбанк: ТТБГазар, ССГазар

Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл

Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

Дүрслэл 15. Бусад салбарын гадаад өр (сая ам.доллар)



ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	II улирал			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2018	2019	2020	Дүн	2019/18	Дүн	2020/19
I. УРСГАЛ ДАНС	-379	-345	-221	34	9%	124	36%
Бараа ба үйлчилгээний худалдаа	-80	33	44	113	142%	11	32%
Кредит	2,267	2,359	1,886	92	4%	-473	-20%
Дебет	2,347	2,326	1,841	-21	-1%	-484	-21%
1. Бараа	355	491	442	135	38%	-48	-10%
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	1,981	2,053	1,745	72	4%	-309	-15%
1.2 Импорт Ф.О.Б (дебет)	1,626	1,562	1,302	-64	-4%	-260	-17%
2. Үйлчилгээ	-435	-458	-398	-22	-5%	59	13%
Кредит	285	306	141	20	7%	-165	-54%
Дебет	721	763	539	42	6%	-224	-29%
2.1 Тээвэр	-158	-168	-58	-10	-6%	110	65%
Кредит	101	110	79	10	9%	-31	-28%
Дебет	259	278	137	19	7%	-141	-51%
2.2 Аялал	-70	-68	-138	2	3%	-71	-104%
Кредит	111	126	2	15	13%	-124	-98%
Дебет	181	194	140	13	7%	-53	-28%
2.3 Бусад үйлчилгээ	-207	-222	-202	-15	-7%	20	9%
Кредит	74	69	60	-4	-6%	-10	-14%
Дебет	281	291	262	10	4%	-29	-10%
3 Анхдагч орлого	-367	-425	-331	-58	-16%	94	22%
Кредит	89	93	82	5	5%	-12	-12%
Дебет	455	518	412	63	14%	-106	-20%
3.1 Ажилчдын цалин	47	45	64	-2	-4%	19	43%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-419	-472	-398	-53	-13%	74	16%
3.3 Бусад	6	2	3	-4	-64%	1	44%
4 Хоёрдогч орлого	68	46	65	-21	-31%	19	41%
Кредит	95	79	87	-16	-16%	8	10%
Дебет	28	33	22	6	20%	-11	-34%
Үүнээс: Хувийн гуйвуулга	11	6	16	-5	-47%	10	176%
II. ХӨРӨНГИЙН ДАНС	27	33	20	6	22%	-13	-39%
1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/бууралт	0	0	0	0		0	
Кредит	0	0	0	0		0	
Дебет	0	0	0	0		0	
2. Хөрөнгийн шилжүүлэг	27	33	20	6	22%	-13	-39%
Кредит	27	33	20	5	20%	-13	-39%
Дебет	1	0	0	-1	-72%	0	-3%
Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээлдэг -)	-352	-313	-201	39	11%	111	36%
III. САНХҮҮГИЙН ДАНС	-355	-541	-109	-186	-52%	432	80%
Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээлдэг -)	-355	-541	-109	-186	-52%	432	80%
1. Шууд хөрөнгө оруулалт	-531	-572	-544	-41	-8%	28	5%
1.1 Актив	2	17	8	15	781%	-10	-56%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	4	17	5	13	380%	-12	-70%
1.1.2 Өрийн хэрэгсэл	-2	0	3	2	110%	2	1463%
1.2 Пассив	533	589	552	56	11%	-37	-6%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	354	294	180	-59	-17%	-115	-39%
1.2.2 Өрийн хэрэгсэл	179	295	372	115	64%	77	26%
2. Багцын хөрөнгө оруулалт	238	-19	576	-257	-108%	595	3157%
2.1 Актив	15	10	12	-5	-34%	2	22%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	13	3	8	-10	-80%	5	209%
2.1.2 Өрийн бичиг	2	8	4	5	204%	-3	-43%
2.2 Пассив	-223	29	-563	252	113%	-592	-2042%
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-1	4	2	5	571%	-2	-48%
2.2.2 Өрийн бичиг	-222	25	-566	247	111%	-590	-2406%
3. Санхүүгийн үсмэл хэрэгслүүд	-41	3	-2	43	106%	-5	-181%
3.1 Актив	-21	2	-3	23	110%	-5	-231%
3.2 Пассив	19	0	-1	-20	-102%	0	-60%
4. Бусад хөрөнгө оруулалт	-22	48	-138	69	320%	-186	-390%
4.1 Актив	-14	-132	205	-118	-826%	338	255%
4.1.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.1.2 Бэлэн мөнгө ба харишцах	-29	-118	156	-89	-306%	274	232%
4.1.3 Зээл	-27	-1	-3	26	96%	-2	-225%
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	42	-13	53	-55	-132%	67	494%
4.1.5 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2 Пассив	7	-180	344	-187	-2559%	524	291%
4.2.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.2.2 Бэлэн мөнгө ба харишцах	-49	-73	2	-24	-49%	75	103%
4.2.3 Зээл	58	-112	445	-171	-293%	558	496%
4.2.3.1 Төв банк	0	0	102	0		102	
4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд	1	-93	24	-95	-7522%	118	126%
4.2.3.3.1 Богино хугацаат	33	3	-28	-30	-89%	-31	-897%
4.2.3.3.2 Урт хугацаат	-32	-97	52	-65	-204%	149	154%
4.2.3.2 Засгийн газар	133	55	357	-77	-58%	302	546%
4.2.3.4 Бусад салбар	-76	-74	-39	1	2%	36	48%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	-2	5	-104	8	327%	-109	-2067%
4.2.6 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2.7 Зээлжих тусгай эрх	0	0	0	0		0	
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-130	236	-329	366	282%	-565	-239%
V. НӨӨЦ ХӨРӨНГӨ	-130	236	-329	366	282%	-565	-239%
1. ГВУН	-93	236	-329	329		-565	
2. ОУВС-гийн зээл	37	0	0	-37		0	
3. Тусгай санхүүжилт	0	0	0	0		0	

* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

Үзүүлэлт	03/31/2019	6/30/2019	9/30/2019	12/31/2019	3/31/2020	6/30/2020
Гадаад хөрөнгө оруулалтын нэвэрлэлт	(34,384)	(34,501)	(34,795)	(35,831)	(35,684)	(36,488)
Актив	6,541	6,874	6,964	7,140	7,129	6,846
Шууд хөрөнгө оруулалт	546	565	584	665	671	688
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	478	497	515	556	566	581
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	478	497	515	556	566	581
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0
Өрийн хэргэсэл	68	69	68	109	105	108
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	68	68	68	108	104	107
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	1	1	1	1	1	1
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0
Байнгын хөрөнгө оруулалт	286	288	286	284	292	320
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	269	262	262	255	263	282
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	22	23	22	22	22	22
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	247	240	240	233	242	260
Бусад санхүүгийн байгууллага	211	214	216	218	227	241
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	36	26	25	15	15	19
Өрийн бичиг	18	25	24	29	29	38
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	7	9	6	6	6	6
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	10	16	17	23	23	32
Бусад санхүүгийн байгууллага	10	10	10	10	10	10
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	6	7	12	12	16
Санхүүгийн үүсмэл хэргэслүүд (нөөцөөс бусад) ба ажигчдын хувьцааны опцион	3	6	5	9	10	7
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	0	0	0	1	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	3	5	4	9	10	7
Санхүүгийн үүсмэл хэргэслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0
Ажигчдын хувьцааны опцион	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	2,052	1,921	2,112	1,841	2,069	2,282
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	1,520	1,402	1,541	1,324	1,549	1,712
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	808	665	873	582	743	946
үүнээс: Банк хоорондын позиц	0	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	712	737	668	742	806	765
Бусад санхүүгийн байгууллага	0	13	27	2	2	4
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	712	724	641	740	804	761
Зээл	156	156	156	145	178	175
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	156	156	156	145	145	145
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	33	30
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	376	364	416	372	341	395
Бусад дансны авлага/оглог	0	0	0	0	0	0
Нөөц хөрөнгө	3,653	4,094	3,978	4,341	4,087	3,548
Мөнгөжсөн алт	656	864	950	1,117	1,220	1,009
Алтан гулдмай	656	864	950	1,117	1,220	1,009
Мөнгөжсөн биет бус алтны данс	0	0	0	0	0	0
Үүнээс: своп хэлцлийн хүрээнд бэлэн валюттаар төлөгдөх Мөнгөжсөн алт	0	0	0	0	0	0
Зээлжих тусгай эрх	54	52	50	49	48	47
ОУВС-д байршуулсан хөрөнгө	0	0	0	0	0	0
Бусад нөөц актив	2,943	3,178	2,978	3,175	2,819	2,493
Бэлэн валют ба харилцах	2,366	2,342	2,451	1,658	2,299	1,974
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч байгууллага дахь	1,803	2,006	2,132	1,437	2,014	1,900
Бусад байгууллагад дахь	563	335	319	221	285	74
Үнэт цаас	576	836	526	1,516	521	519
Өрийн бичиг	576	836	526	1,516	521	519
Хөрөнгийн хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэргэслүүд	0	0	0	0	0	0
Бусад актив	0	0	0	0	0	0

Үзүүлэлт	03/31/2019	6/30/2019	9/30/2019	12/31/2019	3/31/2020	6/30/2020
Гадаад пассив	40,925	41,375	41,759	42,971	42,813	43,334
Шууд хөрөнгө оруулалт	20,674	21,230	21,687	22,556	22,931	23,469
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	11,304	11,583	11,864	12,189	12,273	12,438
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	11,304	11,583	11,864	12,189	12,273	12,438
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0
Өрийн хэрэгсэл	9,370	9,647	9,822	10,366	10,658	11,030
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	9,370	9,647	9,822	10,366	10,658	11,030
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0
Багийн хөрөнгө оруулалт	5,392	5,431	5,412	5,430	4,746	4,329
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	74	77	78	79	79	81
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	21	20	20	20	20	20
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	53	57	58	59	59	61
Бусад санхүүгийн байгууллага	21	25	26	26	24	24
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	32	31	32	33	35	37
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	5,318	5,354	5,334	5,351	4,667	4,248
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	631	622	627	609	622	86
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	3,117	3,107	3,095	3,123	2,488	2,753
Бусад салбарууд	1,569	1,625	1,612	1,619	1,558	1,410
Бусад санхүүгийн байгууллага	1,126	1,124	1,123	1,118	1,039	1,016
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	443	501	489	501	519	393
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	1	1
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	0	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллагууд	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0
Опцион	0	0	0	0	0	0
Форвард хэлбэрийн хэлцлүүд	0	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	14,858	14,714	14,660	14,985	15,135	15,535
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	2,194	2,081	2,012	2,039	2,020	2,028
Төв банк	1,786	1,747	1,683	1,717	1,692	1,698
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	397	334	329	322	328	330
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	11	0	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллага	11	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0
Зээл	12,404	12,341	12,375	12,629	12,736	13,220
Төв банк	287	286	265	268	281	386
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	1,352	1,274	1,250	1,207	1,263	1,287
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	4,307	4,341	4,335	4,683	4,748	5,139
Бусад салбарууд	6,459	6,439	6,526	6,471	6,444	6,408
Бусад санхүүгийн байгууллага	300	322	415	428	406	389
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	6,159	6,117	6,111	6,042	6,038	6,019
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	260	292	273	318	379	288
Бусад дансны авлага/оглог	0	0	0	0	0	0

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨР (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2018	3/31/2019	6/30/2019	9/30/2019	12/31/2019	3/31/2020	6/30/2020
Засгийн газар	7,184	7,424	7,448	7,430	7,806	7,236	7,891
Богино хугацаат	-	-	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	7,184	7,424	7,448	7,430	7,806	7,236	7,891
Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	-	-	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	2,946	3,117	3,107	3,095	3,123	2,488	2,753
Зээл	4,238	4,307	4,341	4,335	4,683	4,748	5,139
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Төвбанк	2,030	2,072	2,034	1,948	1,985	1,973	2,084
Богино хугацаат	1,745	1,786	1,747	1,683	1,717	1,692	-
Харилцах, хадгаламж 5/	1,745	1,786	1,747	1,683	1,717	1,692	-
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	286	287	286	265	268	281	2,084
Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	286	287	286	265	268	281	386
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	1,698
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2,230	2,380	2,230	2,205	2,138	2,212	1,703
Богино хугацаат	764	776	717	677	610	626	600
Харилцах, хадгаламж 5/	327	397	334	329	322	328	330
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-	-
Зээл	437	378	383	348	288	298	270
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	1,466	1,605	1,513	1,529	1,528	1,586	1,103
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	624	631	622	627	609	622	86
Зээл	842	973	891	902	919	965	1,017
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Бусад салбарууд	8,042	8,299	8,356	8,411	8,407	8,381	8,106
Богино хугацаат	609	522	559	521	562	622	498
Харилцах, хадгаламж 5/	51	11	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	2	2	2	2	2	2	2
Зээл	275	269	285	266	262	261	228
Худалдааны зээл болон урьдчилгаа	281	240	272	253	298	359	268
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	7,433	7,778	7,797	7,890	7,845	7,759	7,608
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	1,239	1,567	1,623	1,610	1,617	1,556	1,408
Зээл	6,187	6,190	6,154	6,260	6,208	6,183	6,180
Худалдааны зээл болон урьдчилгаа	7	20	20	20	20	20	20
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	9,228	9,370	9,647	9,822	10,366	10,658	11,030
Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг	9,228	9,370	9,647	9,822	10,366	10,658	11,030
Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг	-	-	-	-	-	-	-
Хамааралтай компани хоорондын өглөг	-	-	-	-	-	-	-
Нийт гадаад өр	28,715	29,546	29,715	29,817	30,702	30,461	30,814